3.5	<p><b>Хог хаягдал.</b></p> <p>Дараах асуудлуудыг багтаасан Материал ашиглалт, хог хаягдлын менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж, замын хэсэг тус бүрээр боловсруулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-д тусгах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Төслийн төлөвлөлтөнд хог хаягдлын менежментийн шатлалыг тусган хэрэгжүүлэх замаар нөөцийн үр ашигтай зарцуулах, улмаар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь боломжтой хэмжээгээр бууруулах.</li> <li>Эргүүлэн ашиглалтын түвшин хамгийн багадаа 60 хувь байх.</li> <li>Авч хэрэгжүүлэх менежментийн арга хэмжээнүүдийг барилгын ажил эхлэхээс өмнө оновчтой төлөвлөх зорилгоор үүсэх хог хаягдал (тэр дундаа аюултай хог хаягдал)-ын төрөл, хэмжээг аль болох урьдчилан тодорхойлох.</li> <li>Үүссэн хог хаягдлыг тодорхой цэгүүдэд зохистой ангилан цуглуулж, хадгалах, устгах журмуудыг боловсруулах.</li> <li>Аюултай материалууд асгарч алдагдахаас сэргийлсэн давхар буюу хоёрдогч савлагаа/бүтцүүдийг бий болгож, төслийн байгууламжуудад хадгалах. Машин, техник хэрэгслийг түлшээр цэнэглэх цэгүүдэд шингэн урсацыг тосох тосгууруудыг байрлуулж, ашиглах.</li> </ul>	Нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх байгаль орчны нөлөөллийн менежмент.	<p>ЕСБХБ ГШЗ.</p> <p>Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагуудад нийцсэн байх.</p> <p>Олон улсын сайн туршлага.</p>	Гэрээт гүйцэтгэгч. Хог хаягдлыг устгах цэг, аргачлалыг ТХН урьдчилан батлах.	<p>Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна.</p> <p>Барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.</p>	<p>Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргаж ТХН-ээр батлуулна.</p> <p>Төлөвлөгөөнүүдийг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.</p> <p>Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.</p>	



№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<ul style="list-style-type: none"> <li>Шатахуун түгээгүүрүүдийг шилжүүлэх, зайлуулах явцад үүсч болзошгүй бохирдлыг магадалж хянах.</li> <li>Барилгын хог хаягдал, аюултай болон бусад хог хаягдлыг хүлээн авч, устгах тусгай зөвшөөрөлтэй байгууламжуудыг тодорхойлох.</li> <li>Хог хаягдлын менежмент, хатуу болон шингэн хог хаягдлыг тээвэрлэх, устгахад шаардлагатай зөвшөөрлүүдийг орон нутгаас авч, холбогдох гэрээнүүдийг байгуулах.</li> <li>Гэрээт гүйцэтгэгчдийн төслийн талбайн гаднах хог хаягдлын менежментийг шалгаж нягтлах арга замуудыг тодорхойлох.</li> </ul>						
3.6	<p><b>Дуу шуугиан, доргио чичиргээний хяналт, холбогдох хяналт шинжилгээ.</b></p> <p>Дуу шуугиан, доргио чичиргээний хяналтын арга хэмжээнүүдийг онцгойлон авч үзсэн замын хэсэг тус бүрээр боловсруулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-г төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх.</p> <p>Төслийн замын трасс ойрхон дайрч өнгөрөх суурингууд, нутгийн хүн амд үзүүлж болзошгүй дуу шуугианы нөлөөллийг тодорхойлох судалгааг төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д тодорхойлсон шаардлагын дагуу гүйцэтгэх.</p>	Нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх байгаль орчны нөлөөллийн менежмент.	ЕСБХБ ГШЗ. Олон улсын сайн туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна. Барилгын ажил эхлэхээс өмнө, мөн барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.	Дэлгэрэнгүй төлөвлөгөөг ТХН-ээр батлуулна. Төлөвлөгөөнүүдийг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна. Барилгын үе шатнаас өмнөх суурь төлөв байдлыг тодорхойлно. Хяналт шинжилгээг барилгын үе шатанд хийнэ. Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	
3.7	<p><b>Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолд тавих хяналт.</b></p> <p>Замын хэсэг тус бүрээр боловсруулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-г төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх. Үүнд ухалт,</p>	Нөлөөлөлд өртөгчдөд үзүүлэх байгаль орчны нөлөөллийн менежмент.	ЕСБХБ ГШЗ. Олон улсын сайн туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна. Барилгын ажлын хугацаанд	Дэлгэрэнгүй төлөвлөгөөг ТХН-ээр батлуулна. Төлөвлөгөөнүүдийг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	дүүргэлт, ажлын зам болон түр ажлын талбай, кэмпүүдтэй холбоотой төлөвлөлтийг хөрсөнд үзүүлэх нөлөөлөл, шимт хөрс хуулалт аль болох багатай байхаар тусгах (жнь: өмнө гаргасан шороон замуудыг ашиглах г.м). Мөн төслийн замын трассын дагуух цэвдэгтэй холбоотойгоор хөрс хамгааллын шаардлагуудыг авч үзэх.				хэрэгжүүлнэ.	Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	
<b>ГШ4</b>	<b>Эрүүл мэнд, аюулгүй байдал</b>						
4.1	<b>Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал.</b> Төслийн талбайн бэлтгэл болон барилгын үе шатуудад талбайд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг чиглүүлэх зорилгоор ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал (АБЭМАБ)-ын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, нэмэлт БОНМХШТ-д тусган шинэчлэх, гэрээт гүйцэтгэгчдээр төлөвлөгөө гаргуулж, хэрэгжилтийг хангах. Төлөвлөгөөнд дараах шаардлагуудыг (үүгээр хязгаарлагдахгүй) тусгасан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Ажил үүрэг бүрээр гаргасан аюулын дүн шинжилгээ, үйл ажиллагаануудад авч хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээ.</li> <li>• Хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-д тавигдах шаардлагууд, ХХХ-ийн хэрэглээ.</li> <li>• Ажилтнуудад зориулсан аюулгүй ажиллагааны сургалт.</li> <li>• Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх.</li> <li>• Гэрээт гүйцэтгэгчийн АБЭМАБ-ын төлөвлөгөө, хэрэгжилт, ТХН-д заавал хүргүүлэх тайланд хяналт тавих.</li> <li>• Нийт ажилласан цаг, ажлын чадвар алдсан цаг, ослын тохиолдлууд, гэмтэл, осолд дөхсөн тохиолдлын статистикийг гаргах.</li> </ul>	Ажиллах хүчний менежментийг ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.  Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.	ЕСБХБ ГШ2. ЕСБХБ ГШ4.  Олон улсын сайн туршлага.  Европын Холбооноос гаргасан Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцоо.	ЗТХЯ / ТХН.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна.	Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын нарийвчилсан төлөвлөгөөг ТХН-ээр батлуулна.  Төлөвлөгөөнүүдийг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.  Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын зааварчилгаа (наряд)-ны хүрээнд эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэж, хуваалцах.</li> <li>Асбест (шөрмөсөн чулуу) зэрэг (жнь: шугам хоолойнд) ашиглахыг хориглосон материалуудыг ашиглахгүй байх.</li> </ul>						
4.2	<p><b>Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал.</b> Төслийн ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ)-ний явцад хэрэгжүүлэх ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах.</p>	<p>Ажиллах хүчний менежментийг ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.</p> <p>Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.</p>	<p>ЕСБХБ ГШ2 ЕСБХБ ГШ4.</p> <p>Олон улсын сайн туршлага.</p> <p>Европын Холбооноос гаргасан Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцоо.</p>	ЗТХЯ / ТХН.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулж, барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.	Төслийн ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ)-ний явцад хэрэгжүүлэх Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын нарийвчилсан төлөвлөгөөг хянуулж, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.	
4.3	<p><b>Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал.</b> Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах журмуудыг боловсруулж, гэрээт гүйцэтгэгчид замын хэсэг тус бүрээр боловсруулах барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-д тусган хэрэгжүүлэх. Журмууд нь дараах (үүгээр хязгаарлагдахгүй) агуулгатай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Барилгын үйл ажиллагааны талаарх мэдэгдлийг олон нийтэд нээлттэй газруудад тавьж, танилцуулах.</li> <li>Томоохон үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний талаарх мэдээллийг ойр орчмын оршин суугчид болон орон нутгийн удирдлагуудад урьдчилан хүргүүлж, мэдэгдэх.</li> <li>Олон нийтэд ойлголт нэмэгдүүлэх сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагаануудыг өндөр</li> </ul>	Зам дээр зорчигчид, орон нутгийн хүн ам, мал сүрэгтэй холбоотой осол, зөрчлийн тохиолдлыг хамгийн бага түвшинд байлгах.	ЕСБХБ ГШ4. Олон улсын сайн туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна. Барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.	Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөө/журмуудыг ТХН-ээр батлуулна. Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөө/журмуудыг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна. Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<p>эрсдэлтэй газар (жнь: хүн ам төвлөрсөн цэг, сургууль г.м), хүн ам (жнь: малчдад мал сүргээ хариулгагүй орхихгүй байхыг анхааруулах г.м)-ын дунд зохион байгуулах замаар нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын дунд эрсдэл болоод холбогдох хяналтын арга хэмжээнүүдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажил эхлэхийн өмнөх зааварчилгаагаар дамжуулан ажилчдад орон нутгийн хүн амд учрах эрсдлүүдээс зайлсхийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаарх ойлголтыг өгөх, аюул ослын анхааруулга/тэмдэг тэмдэглэгээ/хаалтууд ашиглах зэргээр аюулгүй ажиллагааны туршлагауудыг барилгын ажлын явцад хэрэгжүүлэх.</li> <li>Барилгын талбайд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.</li> </ul>						
4.4	<p><b>Зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал.</b></p> <p>БОНМХШТ-ний бүрдэл хэсэг болох тээврийн хэрэгслийн хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д нийцүүлэн боловсруулах. Төлөвлөгөөнд дараах наад захын шаардлагуудыг тусгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Хүнд машин механизм болон ердийн тээврийн хэрэгслүүд зорчих түр замууд болон барилгын хүнд машин механизмын хөдөлгөөнийн менежмент.</li> <li>Орон нутгийн хүн амын хэрэгцээнд зориулсан аюулгүй орц, гарцуудыг</li> </ul>	<p>Зам дээр зорчигчид, орон нутгийн хүн ам, мал сүрэгтэй холбоотой осол, зөрчлийн тохиолдлыг хамгийн бага түвшинд байлгах, орон нутгийн хүрээнд ашиглах орц, гарцуудыг гаргах.</p>	<p>ЕСБХБ ГШ4. Олон улсын сайн туршлага.</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч.</p>	<p>Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна.</p> <p>Барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.</p>	<p>Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөө/журмуудыг ТХН-ээр батлуулна.</p> <p>Төлөвлөгөө/журмуудыг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.</p> <p>Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.</p>	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<ul style="list-style-type: none"> <li>• төлөвлөж, гаргах.</li> <li>• Малын түр гармуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тараах.</li> <li>• Барилгын ажлын тээврийн хэрэгслүүд зөвхөн зөвшөөрөгдсөн зам, чиглэлд зорчиж, хурдны хязгаарлалтыг мөрдөх замаар орон нутгийн хүн ам, бусад зам ашиглагчдад учруулах эрсдлийг бууруулах.</li> <li>• Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг чиглүүлэгч, дохиочин ажиллуулах зэрэг менежментийн арга хэмжээгээр дамжуулан барилгын ажлын тээврийн хэрэгслүүд болон бусад зам ашиглагчдын хөдөлгөөнийг зохицуулах.</li> <li>• Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг илүү нарийн зохицуулалтыг замын цагдаатай хамтран хэрэгжүүлэх.</li> </ul>						
4.5	<p><b>Зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аюулгүй байдал.</b></p> <p>Замын аюулгүй байдлын аудитын хүрээнд ЕСБХБ-аас өгсөн замын аюулгүй байдлын зөвлөмжүүдийг зураг төсөлд тусгах, хүлээн зөвшөөрсөн зөвлөмжүүдэд орох аливаа өөрчлөлтийг ЕСБХБ-д танилцуулж, урьдчилан батлуулах.</p>	Зам дээр зорчигчид, орон нутгийн хүн ам, мал сүрэгтэй холбоотой осол, зөрчлийн тохиолдлыг хамгийн бага түвшинд байлгах.	ЕСБХБ ГШ4, ГШ1. ISO 39001 стандарт.	Дотоод нөөц бололцоо (ЗТХЯ).	Зураг төслийн эцсийн буюу батлагдсан хувилбарт.	Санал болгосон арга хэмжээнүүдийг зураг төслийн батлагдсан хувилбарт оруулна.	
4.6	<p><b>Зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аюулгүй байдал.</b></p> <p>Замын аюулгүй байдлын аудитын шалгалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх байдлаар замын трасс болон суурин газруудтай холбогдох замын аюулгүй ажиллагааг үнэлэх, аливаа аюултай нөхцөл байдлыг илрүүлэх. Зураг төсөл боловсруулах шатанд хийгдсэн замын аюулгүй байдлын аудитын шалгалтаас</p>	Зам дээр зорчигчид, орон нутгийн хүн ам, мал сүрэгтэй холбоотой осол, зөрчлийн тохиолдлыг хамгийн бага түвшинд байлгах.	ЕСБХБ ГШ4, ГШ1. ISO 39001 стандарт.	Дотоод нөөц бололцоо (ЗТХЯ).	Барилгын ажил дууссаны дараа буюу нээлтээс өмнө. Замыг нээснээс 12 сарын дараа. 3 жил тутамд.	Замын аюулгүй байдлын аудитын шалгалтыг барилгын ажил дууссаны дараа буюу замын нээлтээс өмнө гүйцэтгэнэ. Замын аюулгүй байдлын аудитын шалгалт. Замын аюулгүй байдлын аудитын	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн эсэхийг баталгаажуулах үүднээс барилгын ажил дууссаны дараах буюу нээлтээс өмнөх үед хийгдэх замын аюулгүй байдлын аудитын шалгалтыг гүйцэтгэх. Замын аюулгүй байдлын аудитын дараагийн шалгалтуудыг барилгын ажил дуусч, замыг нээснээс 12 сарын дараа, цаашдаа 3 жил тутамд давтан хийж, зам дээр зорчих тээврийн хэрэгслийн осол аваарын тохиолдлыг үнэлж, засаж сайжруулах арга хэмжээ шаардлагатай аливаа хандлага/хар цэгүүдийг тодорхойлох.					шалгалт.	
4.7	<b>Байгалийн аюулт үзэгдэл.</b> Үерийн ус зайлуулах суваг, гүүрийн төлөвлөлт, овоолго/жалганы налуугийн тогтворжилт болон хүчтэй аадар борооны улмаас тогтворжилт алдагдсан үед авах арга хэмжээний мэдээллээр хангах.	Уур амьсгалд дасан зохицох, даван туулах, зам ашиглагчид болоод орон нутгийн хүн амд учрах эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зураг төсөлд тусгах.	ЕСБХБ ГШ4, ГШ1.	ЗТХЯ-ны дотоод нөөц бололцоо, зураг төслийн зөвлөх, МСРС ХХК.	Зураг төслийн эцсийн буюу батлагдсан хувилбарт.	Зохих арга хэмжээнүүдийг зураг төслийн батлагдсан хувилбарт оруулна.	
4.8	<b>Өвчинд өртөлт.</b> Дараах наад захын шаардлагуудыг тусгасан өвчинд өртөлтийг хянахад чиглэсэн журмуудыг төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>• Өвчний хяналтын арга хэмжээнүүд.</li> <li>• ОУСК/ ЕСБХБ-ы шаардлага (ялангуяа эрүүл ахуй, ариун цэврийн стандарт)-д нийцүүлэн ажилчдын кэмпүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд.</li> <li>• Ажилчид, нийт хүн амд тохиолдож болзошгүй аливаа БЗХӨ-ний эрсдлийг илрүүлэх зорилгоор нийт ажилчдыг эрүүл</li> </ul>	Өвчний тархалтыг хамгийн бага түвшинд байлгах.	ЕСБХБ ГШ4. Олон улсын сайн туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна. Барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.	Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөө/журмуудыг ТХН-ээр батлуулна. Төлөвлөгөө/журмуудыг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна. Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<p>мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажилчдад холбогдох зааварчилгааг өгөх.</li> </ul>						
4.9	<p><b>Гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ.</b></p> <p>Замын хэсэг тус бүрээр боловсруулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-ний бүрдэл хэсэг болох Гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг төслийн нэмэлт БОННУ/БОНМХШТ-д нийцүүлэн талбайд барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулах. Төлөвлөгөөнд дараах наад захын шаардлагуудыг тусгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Болзошгүй гамшгуудыг тодорхойлж, эрсдлийн үнэлгээ хийх.</li> <li>Талуудын хүлээх үүрэг, хариуцлага.</li> <li>Тодорхойлсон болзошгүй гамшгийн үед авах хариу арга хэмжээний журмуудыг боловсруулах.</li> <li>Анхны тусламжийн, гал унтраах г.м шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд.</li> <li>Гамшиг, ослын үед ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдэд хийх үзлэг шалгалтын хуваарь.</li> <li>Цуглах цэгүүд, нүүлгэн шилжүүлэх зам, чиглэлүүд.</li> <li>Сургалтын шаардлага.</li> <li>Ажилчид, олон нийт, гамшигт өртсөн бусад талуудтай холбогдох, харилцах протокол.</li> <li>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамгийн ойрын цэгүүдийн байршил.</li> <li>Төлөвлөгөөг хянаж, шинэчлэх хуваарь.</li> </ul> <p>Энэхүү төлөвлөгөөг орон нутгийн хүн ам, холбогдох удирдлага, онцгой байдлын үед үүрэг</p>	<p>Гамшгийн бэлэн байдлыг хангах замаар сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах.</p>	<p>ЕСБХБ ГШ4. Олон улсын сайн туршлага.</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч.</p>	<p>Барилгын ажил эхлэхээс өмнө боловсруулна.  Барилгын ажлын хугацаанд хэрэгжүүлнэ.</p>	<p>Менежментийн дэлгэрэнгүй төлөвлөгөө/журмуудыг ТХН-ээр батлуулна.  Төлөвлөгөө/журмуудыг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна.  Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал, жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.</p>	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	гүйцэтгэх байгууллагуудын төлөөллийг оролцуулан боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд харгалзах гүйцэтгэлийн шаардлагуудыг тусгасан байна. Төлөвлөгөөг төслийн талбайд барилгын ажил эхлэхээс өмнө бэлэн болгох.						
4.10.	<p>Дуу шуугианы нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд (жнь: дуу шуугиан тусгаарлагч г.м)-ийг замыг өргөтгөсөн, мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор дуу шуугианы түвшин зөвшөөрөгдсөн хязгаараас хэтрэх байршлуудад харгалзах зураг төсөлд тусгах. Энэ нь одоо, эсвэл ирээдүйд хийх нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдахгүй нөлөөлөлд өртөгчдөд хамаатай (жнь: иргэдийн хөрөнгө).</p> <p>Дуу шуугианы нөлөөлөлд өртөгчид, суурьшлын бүсүүдэд барилгын үе шатны дараа дуу шуугианы хяналт шинжилгээг хийх, дуу шуугианы түвшин стандартаас хэтэрсэн тохиолдолд дуу шуугиан бууруулах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх (жнь: дуу шуугиан тусгаарлагч).</p>	Хүн амд үзүүлэх дуу шуугианы нөлөөллөөс зайлсхийх.	ЕСБХБ ГШ4	Дотоод нөөц бололцоо (ЗТХЯ).	<p>Барилгын үе шатнаас өмнө.</p> <p>Барилгын үе шатны дараа, дуу шуугианы хяналт шинжилгээний үр дүнд тулгуурлан.</p>	<p>Дуу шуугиан тусгаарлагчдыг зураг төсөлд тусгана.</p> <p>Дуу шуугианы хяналт шинжилгээний хөтөлбөр.</p> <p>Дуу шуугианы нөлөөллийг бууруулахад чиглэсэн засаж сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө.</p>	
<b>ГШ5</b>	<b>Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөлөөлөл</b>						
5.1	<p><b>Зөвлөлдөх уулзалтууд ба Гомдол барагдуулах механизм.</b></p> <p>Талуудын оролцоог хангах төлөвлөгөө, Гомдол барагдуулах албан ёсны механизмыг хэрэгжүүлэх, газар чөлөөлөлт болон/эсвэл амьжиргаа нь түр болон бүр мөсөн нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх уулзалтуудыг үргэлжлүүлэн хийх.</p> <p>Газар чөлөөлөлттэй холбоотой санал, гомдлуудыг барагдуулах механизмын бүртгэлийг ТХН тогтмол хөтлөх.</p>	Үл ойлголцлоос зайлсхийх, газар чөлөөлөх үйл ажиллагааны мэдээллийг цаг алдалгүй хүргэх.	ЕСБХБ ГШ5.	ЗТХЯ / ТХН.	Тогтмол.	Төслийн газар чөлөөлөлттэй холбоотой санал гомдлыг барагдуулах механизм, холбогдох бүртгэл.	



№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
5.2	<p><b>Газар чөлөөлөлттэй холбоотой баримт бичгийн бүрдүүлэлт.</b></p> <p>Нөлөөлөлд өртсөн талуудтай холбоотой бүх мэдээлэл, байгуулсан гэрээнүүдийг баримтжуулж бүрдүүлэх.</p> <p>Нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллээр хангах.</p> <p>Төслийн нөлөөллийн бүсэд байрлах байгууламжуудын байршлын зураг, жагсаалтыг гаргах.</p>	ЕСБХБ-ы шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ5.	ЗТХЯ / ТХН.	<p>Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэхээс өмнө буюу 2019 оны 6-р сарын дундуур.</p> <p>Олон нийтэд нээлттэй танилцуулах мэдээллийн нэг хэсэг болно.</p>	Газар чөлөөлөх төлөвлөгөө, нөлөөлөлд өртсөн талтай байгуулсан гэрээнүүд.	
5.3	<p><b>Газар чөлөөлөх үйл ажиллагаа.</b></p> <p>Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцооны дагуу боловсруулж, хэрэгжүүлэх.</p> <p>Нөлөөлөлд өртөгчдөд нөхөн олговрыг төслийн талбайд барилгын ажил эхлэхээс өмнө олгох.</p>	<p>Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцоог боловсруулах.</p> <p>ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.</p>	ЕСБХБ ГШ5.	ЗТХЯ / ТХН.	Тодорхойлсон байгууламж/хөрөнгөнд нөлөө үзүүлэх барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө.	Газар чөлөөлөлт, нөхөн олговортой холбоотой бүх үйл ажиллагааны бүртгэлийг Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд тусгана.	
5.4	<p><b>Газар чөлөөлөлттэй холбоотой баримт бичгийн бүрдүүлэлт, хэрэгжилт.</b></p> <p>Түр болон байнгын зорилгоор газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, эсвэл бодит болоод эдийн засгийн нөлөөлөл, шилжилтэнд хүргэх түр газар ашиглалтын шаардлагууд (жнь: барилгын кэмпүүд барих, карьерууд, ажлын зам г.м)-ыг Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцооны дагуу хэрэгжүүлэх. Шаардлагатай буюу боломжтой тохиолдолд Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцооны</p>	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ5	Гэрээт гүйцэтгэгч.	Тодорхойлсон байгууламж/хөрөнгөнд нөлөө үзүүлэх барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө.	<p>Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө.</p> <p>Олгосон нөхөн олговрууд.</p> <p>Холбогдох санал гомдлын тоо.</p>	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	дагуу боловсруулж, хэрэгжүүлэх. Энэ хүрээнд ТХН-тэй хамтран ажиллах. Нөлөөлөлд өртөгчдөд нөхөн олговрыг төслийн талбайд барилгын ажил эхлэхээс өмнө олгох.						
5.5	<b>Хяналт шинжилгээ.</b> Газар чөлөөлөлт, нөхөн олговортой холбоотой үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх замаар ЕСБХБ ГШ5/ Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцооны шаардлагуудын нийцлийг хангах. Аливаа зөрүү гарвал ТХН-д мэдэгдэж, шийдвэрлэх.	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ5.	ЗТХЯ / ТХН.	Газар чөлөөлөлт дууссаны дараа.	ЕСБХБ-ны аудит/хяналтын тайлан.	
5.6	<b>Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (НШТ)-тэй холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт, төлөвлөгөөний хэрэгжилт.</b> Замын 50 м зурвас дотор төслийн хүрээнд ирээдүйд нүүлгэн шилжүүлэлтэд өртөх барилга байгууламжууд байгаа тохиолдолд НШТ-г ГЧНШХХ-ний дагуу боловсруулж, хэрэгжүүлэх. Холбогдох нөхөн олговрыг нөлөөлөлд өртөх барилга байгууламжуудыг нүүлгэн шилжүүлэхээс өмнө олгох.	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ5.	ЗТХЯ	Тодорхойлсон барилга байгууламжуудад нөлөө үзүүлэх барилгын ажлуудыг эхлүүлэх зөвшөөрөл өгөхөөс өмнө.	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө. Олгосон нөхөн олговрууд. Холбогдох санал гомдлын тоо.	
5.7	<b>Хяналт шинжилгээ.</b> Төгсгөлийн албан ёсны аудитын шалгалт.	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ5.	ЕСБХБ.	Газар чөлөөлөлт дууссаны дараа.	Төслийн төгсгөлд хийх аудит.	
<b>ГШ6</b>	<b>Биологийн олон янз байдал ба байгалийн нөөц</b>						
6.1	<b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах.</b> Зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөн, тархалтын судалгаа (энд халиун буганы нүүдлийн замыг хамарсан мэргэжлийн судалгаа багтана).	Биологийн олон янз байдлыг хамгаалах. ЕСБХБ болон улс орон, орон нутгийн холбогдох шаардлагуудад	ЕСБХБ ГШ1, ГШ6. Орон нутгийн шаардлагууд. Олон улсын шилдэг туршлага.	ЗТХЯ.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө.	Судалгааг гүйцэтгэж, шаардлагатай арга хэмжээнүүдийг зураг төсөлд тусгана.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	Нэмэлт арга хэмжээнүүдийг мэргэжилтний зөвлөмжид түшиглэн төлөвлөж, хэрэгжүүлэх. Үүнд жишээ нь хурдны хязгаар тогтоох, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах зэрэг байж болно.	нийцүүлэх.					
6.2	<b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах.</b> Шувуудын үржил, бойжлын үед модыг хөндөхөөс зайлсхийх. Ингэх боломжгүй тохиолдолд, ажил гүйцэтгэхээс өмнө экологич буюу холбогдох мэргэжилтнийг талбайд авч ирж, шувууны идэвхитэй үүр байгаа эсэхийг тодорхойлох. Идэвхитэй үүр ажиглагдвал дэгдээхий бойжиж, үүрээ орхих хүртэл тэдгээр үүрийг хөндөхөөс зайлсхийх, экологич, мэргэжилтнээс дэлгэрэнгүй зөвлөгөө авах.	Биологийн олон янз байдлыг хамгаалах ЕСБХБ болон Европын Холбооноос гаргасан Шувуу хамгаалах стандартын шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ6. ЕХ-ны Шувуу хамгаалах стандарт. Олон улсын шилдэг туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Модыг шилжүүлэхээс өмнө.	Барилгын ажил эхлэхээс өмнөх үеийн тайлан.	
6.3	<b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах.</b> Шаардлагатай тохиолдолд, төслийн зүгээс тусгай хамгаалалттай газар нутгуудтай холбоотой зөвшөөрлүүдийг ажил эхлэхээс өмнө холбогдох орон нутгийн удирдлагуудаас авах, хамгаалал, хамгааллын зорилгыг алдагдуулахгүй байх. Энд барилгын материал тээвэрлэх, барилгын машин механизм зорчих зам, түр талбайнуудыг байршлаас нь хамаарч мөн хамруулна.	Биологийн олон янз байдлыг хамгаалах. ЕСБХБ болон улс орон, орон нутгийн холбогдох шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ6. Орон нутгийн шаардлага. Олон улсын шилдэг туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө.	Холбогдох зөвшөөрлүүд.	
6.4	<b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах.</b> Барилгын ажил эхлэхээс өмнө тарваганы судалгааг гүйцэтгэх. Төслийн нөлөөлөлд өртөх талбайд тарваганы идэвхитэй нүх (нүхэнд тарвага байгаа) тогтоогдвол байгаль хамгаалах мэргэжлийн байгууллагуудад хандан, тарвагануудыг нүүлгэн шилжүүлэх.	Биологийн олон янз байдлыг хамгаалах. ЕСБХБ болон улс орон, орон нутгийн холбогдох шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ6. Орон нутгийн шаардлага. Олон улсын шилдэг туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө.	Судалгааг гүйцэтгэж, сар тутмын тайланд тусгана.	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
6.5	<b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах.</b> Зайлуулсан буюу нүүлгэн шилжүүлсэн моднуудыг тухайн газарт нь 2:1 харьцаагаар нөхөн тарих. Энэ ажлыг гэрээт гүйцэтгэгчийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.	Биологийн олон янз байдлыг хамгаалах. ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ6. Олон улсын шилдэг туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажлын дараа.	Нөхөн сэргээлтийн ажлын тайлан. Моднуудыг нөхөж тарих буюу шилжүүлэн суулгана.	
<b>ГШ7</b>	<b>Уугуул иргэд</b>						
7.1	Энэ төсөлд хамаарахгүй.						
<b>ГШ8</b>	<b>Соёлын өв</b>						
8.1	<b>Соёлын өвд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, удирдах.</b> Замын трассын дагуу болон барилгын ажлын талбайнуудын хэмжээнд археологи, палеонтологи, угсаатны нарийвчилсан судалгааг Монгол Улсын холбогдох хуулийн шаардлагад нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Соёлын өвийн ач холбогдолтой газруудыг хамгаалах. Уламжлал, ёс заншилд хүндэтгэлтэй хандах. Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх.	ЕСБХБ ГШ1, ГШ8. Монгол Улсын хууль. Олон улсын шилдэг туршлага.	Дотоод нөөц бололцоо (ЗТХЯ). Бусад нөөц бололцоо – холбогдох яамнаас батламжилсан соёлын өвийн мэргэжилтэн/ мэргэжлийн байгууллага.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө болон гэрээт гүйцэтгэгчийн сонгож тодорхойлохоос өмнө.	Барилгын үе шат эхлэхээс өмнө гүйцэтгэсэн археологи, палеонтологи, угсаатны нарийвчилсан судалгааны тайлан.	
8.2	<b>Соёлын өвд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, удирдах.</b> Төслийн талбайн тодорхой хэсэгт зориулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-ний бүрдэл хэсэг болох Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө, Соёлын өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журмыг боловсруулж, хэрэгжүүлэх. Соёлын өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журмыг танилцуулах сургалтыг	Соёлын өвийн ач холбогдолтой газруудыг хамгаалах. Уламжлал, ёс заншилд хүндэтгэлтэй хандах.	ЕСБХБ ГШ1, ГШ8. Олон улсын шилдэг туршлага.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө боловсруулж, барилгын үе шатанд хэрэгжүүлнэ.	Төслийн талбайн тодорхой хэсэгт зориулсан барилгын ажлын нарийвчилсан БОНМХШТ-ний бүрдэл хэсэг болох Соёлын өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам. Төлөвлөгөө/журмуудыг ЕСБХБ-д хүргүүлж хянуулан, татгалзах зүйлгүйг баталгаажуулна. Гэрээт гүйцэтгэгчид барилгын үе шатанд явцын тайланг сар, улирал,	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	зохион байгуулах.					жилийн давтамжтай гаргаж, ТХН-д хүргүүлнэ.	
<b>ГШ10</b>	<b>Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо</b>						
10.1	<p><b>Барилгын үе шатны Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), замын ашиглалтын үе шатны Гомдол барагдуулах механизм.</b></p> <p>Нэмэлт буюу төслийн ТОХТ-нд тулгуурлан барилгын үе шатанд хэрэгжүүлэх нарийвчилсан ТОХТ-г замын хуваарьт хэсэг тус бүрээр боловсруулж, ТХН-ээр батлуулах.</p> <p>Гэрээт гүйцэтгэгчид олон нийттэй харилцах ажилтныг томилж ажиллуулах.</p> <p>Хүн амд нөлөө үзүүлж болзошгүй төслийн үйл ажиллагааны талаар иргэд, оршин суугчдад урьдчилан мэдээлэл өгч, анхааруулах.</p> <p>Хүмүүс цугларсан цэгүүд, сургууль г.м өндөр эрсдэлтэй газруудын ойролцоо барилгын ажил гүйцэтгэх үед нөлөөлөлд өртөх эрсдэлтэй бүлгүүдийг хамруулсан (жнь: малчид – малаа хариулгагүй бэлчээхгүй байх г.м) ойлголт нэмэгдүүлэх, мэдээлэл өгөх сургалт, уулзалтуудыг хийх.</p> <p>Гомдол барагдуулах механизмын ажиллагааг хангах, бүртгэл хөтөлж тайлагнах.</p>	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ10.	Гэрээт гүйцэтгэгч.	Барилгын ажлууд хийгдэж эхлэхээс өмнө боловсруулж, барилгын үе шатанд хэрэгжүүлнэ.	<p>Гэрээт гүйцэтгэгчид өөрсдийн хуваарьт хэсэгт харгалзах ТОХТ-г боловсруулж ТХН-ээр батлуулна.</p> <p>Гэрээт гүйцэтгэгчид нь олон нийттэй харилцах офис, цэгүүдийг тодорхойлж байгуулна.</p> <p>Гомдол барагдуулах механизмын бүртгэл, тайлан.</p>	
10.2	<p><b>Барилгын үе шатны Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), замын ашиглалтын үе шатны Гомдол барагдуулах механизм.</b></p> <p>Төслийн ерөнхий ТОХТ-нд багтах нэмэлт ТОХТ-үүдийг боловсруулах г.м талуудын оролцоог хангах үйл явцыг ерөнхийд нь удирдаж,</p>	ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэх.	ЕСБХБ ГШ1, ГШ10.	ЗТХЯ / ТХН.	Барилгын үе шатанд хэрэгжүүлнэ.	<p>Талуудын оролцоог хангахад чиглэсэн төслийн ерөнхий стратеги.</p> <p>Замын хэсгүүдийг хариуцсан гэрээт гүйцэтгэгчдийн талуудын оролцоог хангах үйл явцыг удирдлагаар хангана.</p>	

№	Арга хэмжээ	Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэл (Хүлээх үүрэг/ Үр өгөөж)	Тавигдах шаардлага (Хууль тогтоомж, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага/ГШ, шилдэг туршлага)	Нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хариуцах тал	Хэрэгжүүлэх хугацаа	Дэвшүүлсэн зорилт ба хэрэгжилтийг үнэлэх шалгуурууд	Хэрэгжилтийн статус
	<p>хэрэгжилтийг хангуулах. Төслийн ТОХТ-нд АХБ/ЕСБХБ-ны төсөл болон замын хэсгүүдийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээт гүйцэтгэгчид гэсэн талуудын оролцоог хангах удирдлагын арга барил зэргийг тусгасан байна.</p> <p>Гэрээт гүйцэтгэгчдийн талуудын оролцоог хангах ажлын гүйцэтгэлийг удирдлагаар хангах, хяналт тавих.</p>						